

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/142/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг:
MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
4. Аудитын тайлан.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХХБ. 03. 27 № 01/300
танай _____ -ны № _____ -т

БАЯНЗҮРХ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ Г.ОДСЭР
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баянзүрх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянзүрх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн нэгтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Хоршоо хөгжүүлсэн сангийн авлагын үлдэгдэл 76.0 сая төгрөг байна. Үүнээс 16 иргэний нийт 21.1 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянзүрх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч Хөвсгөл аймгийн Засаг даргатай тайлант онд 10 чиглэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллахаар гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг 86.4 хувиар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх

хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/Мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	919,563.9	309,244.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	248,715.4	201,534.6
33	АВЛАГА	143,130.0	75,995.9
34	УРЬДЧИЛГАА	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	527,718.5	31,713.5
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,834,811.8	3,833,956.4
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	57,417.5	152,453.6
37300	Урт хугацаат зээл	57,417.5	152,453.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,777,394.3	3,681,502.8
39200	Биет хөрөнгө	9,610,372.8	3,654,802.0
39300	Биет бус хөрөнгө	167,021.5	26,700.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	10,754,375.6	4,143,200.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,059.3	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,059.3	0.0
41300	Өглөг	8,059.3	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,746,316.3	4,143,200.4
51	Засгийн газрын хувь оролцоо	10,746,316.3	4,143,200.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,527,995.8	327,386.9
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,527,995.8	327,386.9
51200	Хуримтлагдсан үр дүн	6,710,771.3	3,293,235.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,507,549.2	522,578.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,754,375.6	4,143,200.4

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,149,739.2	1,241,665.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	224,829.3	392,034.9
110	Орлогын албан татвар	78,325.8	218,153.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	78,325.8	227,565.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-9,412.0
113	Хөрөнгийн албан татвар	68,129.9	71,352.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	78,373.6	102,530.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,228,751.2	173,705.4
120	Нийтлэг татварын бус орлого	2,228,751.2	173,705.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,696,158.6	675,925.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,283,267.0	1,133,918.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,283,267.0	1,133,918.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,438,910.0	958,566.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,972,177.1	413,153.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	255,277.5	52,536.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,960.5	135,785.7
2104	Хангамж, бараа материалын зардал	104,209.2	34,686.9
2105	Нормативт зардал	370,399.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,198.2	26,488.6
2107	Томилолт, зочны зардал	5,887.2	2,770.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,220.3	29,388.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	558,581.0	263,757.1
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	844,357.0	175,352.0

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,866,472.1	107,747.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	145,748.4	6,657,777.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,720,723.8	-6,550,029.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,013,936.3	1,136,504.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	224,829.3	392,034.9
110	Орлогын албан татвар	78,325.8	218,153.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	78,325.8	227,565.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-9,412.0
113	Хөрөнгийн албан татвар	68,129.9	71,352.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	78,373.6	102,530.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,427.4	5,832.2
1181	Газрын төлбөр	2,285.2	7,042.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	70,660.9	89,655.2
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	152,480.3	68,544.4
120	Нийтлэг татварын бус орлого	152,480.3	68,544.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,636,626.7	675,925.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,645,966.3	1,023,433.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,645,966.3	1,023,433.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,802,523.7	717,586.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,971,934.7	413,246.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	255,145.3	52,418.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,949.7	135,448.4
2104	Хангамж, бараа материалын зардал	99,741.8	34,080.9
2105	Нормативт зардал	206,446.7	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,030.3	29,829.6
2107	Томилолт, зочны зардал	5,887.2	2,770.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,395.0	29,655.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,993.0	20,136.7
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	843,442.6	305,847.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	367,970.0	113,071.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	163,198.2	10,252.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	163,198.2	10,252.0
2200	Дотоод эх үүсвэрээр	163,198.2	10,252.0
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-163,198.2	-10,252.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-78,000.0	-150,000.0
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	78,000.0	150,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	126,771.8	-47,180.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	121,943.6	248,715.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	248,715.4	201,534.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь	Нийт цэвэр хөрөнгө/өмч
------	---------------------	---------------------	------------------------

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

		оролцооны нийт дүн	
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,025,592.6	9,025,592.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,293.4	3,293.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,028,886.0	9,028,886.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-3,293.4	-3,293.4
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	1,720,723.8	1,720,723.8
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,746,316.3	10,746,316.3
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,746,316.3	10,746,316.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-53,086.2	-53,086.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,693,230.2	10,693,230.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-6,550,029.8	-6,550,029.8
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,143,200.4	4,143,200.4

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,266,146.80	1,152,759.04	113,387.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,116,146.80	1,002,759.04	113,387.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	718,996.20	713,608.45	5,387.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	411,170.70	411,146.76	23.94
210101	Үндсэн цалин	405,615.10	340,858.21	64,756.89
210102	Нэмэгдэл	2,000.00	52,713.33	-50,713.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00	0.00
210104	Урамшуулал	3,555.60	17,575.22	-14,019.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,488.60	52,418.77	69.83
210201	Тэтгэврийн даатгал	35,688.90	35,624.48	64.42
210202	Тэтгэмжийн даатгал	4,218.60	4,214.93	3.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,358.30	3,355.94	2.36
210204	Ажилгүйдлийн даатгал	827.10	836.36	-9.26
210205	Эрүүл мэндийн даатгал	8,395.70	8,387.06	8.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140,642.00	135,448.41	5,193.59
210301	Гэрэл, цахилгаан	35,421.00	31,009.07	4,411.93
210302	Түлш, халаалт	100,421.00	99,831.28	589.72
210303	Цэвэр, бохир ус	4,800.00	4,608.06	191.94
2104	Хангамж, бараа материалын зардал	30,494.90	30,394.90	100.00
210401	Бичиг хэрэг	4,999.10	5,226.00	-226.90
210402	Тээвэр, шатахуун	21,591.50	21,364.60	226.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,204.30	3,204.30	0.00
210404	Ном, хэвлэл	700.00	600.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,877.60	31,877.60	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,506.90	5,506.90	0.00

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	26,370.70	26,370.70	0.00
2107	Томилолт, зочны зардал	2,770.00	2,770.00	0.00
210702	Дотоод албан томилолт	2,770.00	2,770.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,635.70	31,635.31	0.39
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,585.70	30,585.31	0.39
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450.00	450.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	160.00	160.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90.00	90.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50.00	50.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300.00	300.00	0.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,916.70	17,916.70	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,679.20	9,679.20	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,237.50	8,237.50	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	397,150.60	289,150.59	108,000.01
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	363,470.90	255,470.89	108,000.01
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	363,470.90	255,470.89	108,000.01
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,679.70	33,679.70	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,963.80	28,963.80	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,715.90	4,715.90	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150,000.00	150,000.00	0.00
230001	Эргэж төлөгдөх зээл	150,000.00	150,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,266,146.80	1,040,623.76	225,523.04
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	163,719.60	229,085.51	-65,365.91
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	163,719.60	229,085.51	-65,365.91
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	818,040.40	745,981.33	72,059.07
320001	Орон нутгийн төсвөөс	818,040.40	745,981.33	72,059.07
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	284,386.80	65,556.92	218,829.88
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,918.00	62,657.89	-2,739.89
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500.00	2,899.03	-1,399.03
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	222,968.80	0.00	
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	147,255.20	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	35,026.74	

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,680.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,680.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,230.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,100.00
210104	Урамшуулал	2,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,686.00
210401	Бичиг хэрэг	540.00
210402	Тээвэр, шатахуун	2,086.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,030.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,224.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,883.00
210602	Тавилга	1,900.00
210604	Урсгал засвар	1,441.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,220.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,920.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,450.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,450.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,450.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,680.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,680.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,674.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,466.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	540.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Баянзүрх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Баянзүрх сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд "Иргэдэд төрийн үйлчилгээг тасралтгүй жигд хүргэх замаар сумын нийгэм эдийн засгийн хөгжлийг хангах" гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна

Тус сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 88.3 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу Соёлын төв, Эрүүл мэндийн төв, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль тус тус улсын төсөвт шилжсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/128 тоот захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, цаг ашиглалт, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулал, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, орон нутгийн орлогын гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа, шилэн дансны мэдээлэл, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянзүрх сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянзүрх сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,611.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	248.7	201.5	-47.2
Авлага	143.1	76.0	-67.1
Бараа материал	527.7	31.7	-496.0
Урт хугацаат зээлийн авлага	57.4	152.4	95.0
Үндсэн хөрөнгө	9,777.4	3,681.5	-6,095.9
Нийт хөрөнгө	10,754.4	4,143.2	-6,611.2
Өр төлбөр	8.1	0.0	-8.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,746.3	4,143.2	-6,603.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,754.4	4,143.2	-6,611.2

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдэж бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн дансны үлдэгдлүүд буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 47.2 сая төгрөгөөр буурсан бөгөөд Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 166.5 сая төгрөг, ОНХС-ийн дансанд 15.0 сая төгрөг,

Хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэлд 20.0 сая төгрөг нийт 201.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Дээрх мөнгөн хөрөнгө нь 201.5 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

2. Авлагын үлдэгдэл 76.0 сая төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын дүн байна. Хоршоо хөгжүүлэх сангийн 16 иргэний 20.0 сая төгрөгийн зээл, 1.1 сая төгрөгийн хүүгийн төлбөрийн эргэн төлөлт хугацаа хэтэрсэн байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1 дэх "орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.
3. Бараа материалын дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв гэсэн 4 байгууллагын тайланг улсын төсөвт шилжүүлэн нэгтгэсэн нь нөлөөлсөн байна.
4. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурахад буурахад Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв гэсэн 4 байгууллагын тайланг улсын төсөвт шилжүүлэн нэгтгэсэн нь нөлөөлсөн байна.
5. Өр төлбөрийн данс 8.1 сая төгрөгөөр буурч үлдэгдэлгүй болсон байна. Тайлант хугацаанд ЗДТГ-ын 0.5 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөгийг барагдуулсан байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 1,241.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 4,908.1 сая төгрөгөөр буюу 79.8 хувиар буурсан байна.

Хүснэгт №2 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	зөрүү
Татварын орлого	224.8	392.0	165.2
Татварын бус орлого	2,228.7	173.8	2,054.9
Тусламж санхүүжилтийн орлого	3,696.2	675.9	-3,020.3
Нийт дүн	6,149.7	1,241.7	-4,908.0

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсөвт шилжиж улсын төсвөөс авах санхүүжилт хасагдсанаас шалтгаалсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 1,037.0 сая төгрөгийн орлогын давхардсан 7 устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд 1,133.9 сая төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрч тайлагнасан байна. Өмнөх онтой харьцуулахад 3,149.3 сая төгрөгөөр буюу 73.5 хувиар буурсан байна.

Хүснэгт №3: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Бараа ажил үйлчилгээний зардал	3,438.9	958.6	-3,149.3	-72.1
Урсгал шилжүүлэг	844.4	175.4	-669.0	-79.2
Үйл ажиллагааны зардлын дүн	4,283.3	1,133.9	-3,149.4	-73.5

Эх сурвалж: Баянзүрх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Нийт зардлын дүн буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжиж орон нутгаас байр ашиглалтын зардлыг санхүүжүүлэх болсноор төсвийн зардал 73.5 хувиар буурахад гол нөлөө үзүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 1,037.0 сая төгрөгийн зарлагын давхардсан 7 устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж орон нутгаас санхүүжүүлэх Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн байгууллагуудын тогтмол зардлыг тусгаж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Баянзүрх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 1,316.9 сая төгрөгийн төсөв баталснаас 793.9 сая төгрөгийг урсгал зардалд, 373.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, Эргэж төлөгдөх зээлийн зардалд 150.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 175.9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, санхүүгийн дэмжлэгээс 651.5 сая төгрөгийг, сумын орон нутгийн орлогоос 326.8 сая төгрөгийг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 61.4 сая төгрөгийг, давсан орлого дансны үлдэгдлээс 101.3 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Баянзүрх сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор төсөвт 131.0 сая төгрөгийн хасах тодотгол хийж төсвийг 1,118.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн орлогын гүйцэтгэл

Гүйцэтгэлээр Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 65.5 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 395.0 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангаас 163.7 сая төгрөгийг, давсан орлого дансны үлдэгдлээс 100.8 сая төгрөгийг, санхүүгийн дэмжлэгээс 491.2 сая төгрөгийг нийт 1,226.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Баянзүрх сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолд зааснаар Баянзүрх сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 326.8 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 395.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 120 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №4. Төвлөрүүлэх орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	6.0	32.1	26.1	535%
Хөрөнгийн орлого	31.0	28.2	(2.8)	91%
Хөрөнгө борлуулсны орлого	2.9	2.3	(0.6)	79%
Шууд бус орлого	-	0.5	0.5	
Цалин хөлс шагнал урамшуулал	120.0	164.4	44.4	137%
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(34.4)	(9.4)	25.0	27%
Бууны албан татвар	2.5	2.4	(0.1)	96%
Малд ногдуулах албан татвар	93.0	62.2	(30.8)	67%
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	5.0	6.7	1.7	134%
Улсын тэмдэгтийн хураамж	5.3	2.2	(3.1)	42%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.5	1.5	1.0	308%
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4.0	2.1	(1.9)	52%
Газрын төлбөр	5.5	3.3	(2.2)	59%
Ойн нөөц ашигласны төлбөр	49.0	56.5	7.5	115%
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	19.0	32.2	13.1	169%
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.2	0.2	-	100%
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.2	0.8	0.6	516%
Торгуулийн орлого	17.1	3.0	(14.1)	17%
Газрын дуудлага худалдаа		3.8	3.8	
Нийт орлого	326.8	395.0	68.2	120.9

Эх сурвалж: Баянзүрх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Баянзүрх сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө 68.2 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар 44.4 сая төгрөгөөр, үйл ажиллагаа эрхэлсний орлогын татвар 26.1 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 13.1 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрөл бүрээр хянаж үзэхэд 8 төрлийн орлого нийт 55.6 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 18.8 сая төгрөгөөр төлөвлөж, 30.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 159 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №5: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/сая төгрөгөөр/	
			Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	1.8	0	-1.8
2	Газрын үл хөдлөх хөрөнгийн татвар			0
3	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	12	24.7	12.7
4	Зам ашигласны төлбөр	5	5.3	0.3
	Нийт дүн	18.8	30.0	11.8

Эх сурвалж: Баянзүрх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 11.8 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 4.1 сая төгрөгөөр төлөвлөж, 9.6 сая төгрөгөөр гүйцэтгэлтэй буюу 232 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №6: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/сая төгрөгөөр/	
			Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1.8	1.2	-0.6
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	1.8	6.0	4.2
3	Агаарын бохирдлын төлбөр	0.5	2.4	1.9
	Нийт дүн	4.1	9.6	5.5

Эх сурвалж: Баянзүрх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 5.5 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 491.9 сая төгрөгөөр төлөвлөж, 491.2 сая төгрөг буюу 99.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 61.4 сая төгрөгийг орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 65.5 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 1,118.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 669.7 сая төгрөгийг урсгал зардалд, 366.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 150.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 647.8 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 258.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,056.0 сая төгрөг буюу 89.0 хувьтай байгаа нь ОНХС-ийн 108.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдээгүйтэй холбоотой байна.

ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлэх 27 төсөл арга хэмжээнд 366.2 сая төгрөг батлагдсанаас 24 төсөл арга хэмжээнд 258.2 сая төгрөгийг зарцуулж 108.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ТТЗ-ийн харьяа байгууллагууд нь хандив тусламжаар 9.7 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 5.5 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 0.5 сая төгрөг, нийт 15.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Дээрх нэмэлт санхүүжилтийн орлогуудыг удирдамж зориулалтын дагуу зарцуулж ажилласан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянзүрх сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Л.Мандахнаран гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Баянзүрх сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/42 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 1.5 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 64.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 51.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,133.9 сая төгрөгийг сонгож 17.0 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баянзүрх сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 11.3 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт №7 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	11.3	3	11.3	100
Нийт дүн	3	11.3	3	11.3	100

/сая төгрөгөөр/

Өмнөх онд хүргүүлсэн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 76.7 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлсэн.

ТТЗ-ийн Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 57.8 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн байна. Төсвийг зориулалт бусаар зарцуулсан 2 зөрчилд 0.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 57.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

5.1 Төлбөрийн акт

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага өгөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

1.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 16 иргэнтэй холбоотой 21.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

2. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр авч үзвэл 8 нэр төрлийн 55.6 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрөл бүрээр төлөвлөгөөг биелүүлж ажиллах

3. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар

3.1. Илрүүлэлт:

ТТЗ-ийн Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 57.8 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн байна. Төсвийг зориулалт бусаар зарцуулсан 2 зөрчилд 0.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 57.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	55.6					1	55.6				
Хугацаа хэтэрсэн зээлийн авлага	1	21.1					1	21.1				

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Харьяа байгууллагуудын зөрчил	1					1				
Дүн	2	128.6				1	76.7			
Харьяа байгууллагуудын зөрчил										
Баянзүрх сумын ЗДТГ	2	57.3	1	0.3		1	57.0			
Баянзүрх сумын ИТХ	1	0.5	1	0.5						
Дүн	3	57.8	2	0.8		1	57.0			

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: ⑤/24

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Л.МАНДАХНАРАН ОГНОО: ③/27

